



**ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2017 оны 03 сарын 17 өдөр

Дугаар A/11.

Чингис хот

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх заалт, Засгийн газрын 340 дүгээр тогтоолыг үндэслэн ТУШААХ нь:

1. Гамшгийн аюулыг зарлан мэдээлэх дохиогоор ажиллах дадлага сургуулийг зохион байгуулах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Ажлын хэсгийн
ахлагч:

Н.Хүрэлээ

-Цэргийн штабын дарга, дэд хурандаа

Гишүүдэд:

Т.Баяраа

-Цэргийн штабын Орон нутгийн хамгаалалт сургалтын офицер, дэд хурандаа

Л.Цэнддорж

-Цэргийн штабын Тоо бүртгэлийн офицер, ахмад

Д.Ганболд

-Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн

Ц.Цэрэндорж

-Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

2. Гамшгийн аюулыг зарлан мэдээлэх дохиогоор ажиллах төлөвлөгөөнд тодотгол хийн батлуулж, аймгийн Засаг даргын Тамгын газрын байранд байрлах байгууллагуудын бүрэлдэхүүнийг бүрэн оролцуулахыг ажлын хэсэг /Н. Хүрэлээ/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР

03 047